

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны 03 сарын 28-ны өдөр

Дугаар 49/А/93

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.9, 14.1.14, Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Зэвсэгт хүчний тусгай цэвэрлэгээний бүлгийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.“Зэвсэгт хүчний тусгай цэвэрлэгээний бүлгийн ажиллах журам”-д нийцүүлэн холбогдох заавар боловсруулан баталж мөрдүүлэхийг Зэвсэгт хүчний Жанжин штаб (хошууч генерал С.Ганбямба)-т хариуцуулсугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга (Б.Мөнх-Оргил), Батлан хамгаалах яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Б.Эрхэмбаяр)-т тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД



С.АМАРСАЙХАН

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД



С.БЯМБАЦОГТ

Монгол Улсын Шадар сайд, Батлан хамгаалахын
сайдын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн
49/НЗ дугаар хамтарсан тушаалын хавсралт

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУСГАЙ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БҮЛГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг, хими, биологийн гаралтай гамшгаас үүдэн хүн, мал, амьтан, барилга байгууламж, газар оронд бохирдол үүссэн үед Зэвсэгт хүчний тусгай цэвэрлэгээний бүлгүүд хор уршгийг арилгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үеийн харилцааг зохицуулахад оршино.

1.2. Цацраг, хими, биологийн гамшгийн үед Зэвсэгт хүчнээс тусгай цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

2.1. Энэхүү журамд заагдсан дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. "тусгай цэвэрлэгээний бүлэг" гэж хордсон газар орон, хүн, мал, барилга байгууламж, техник, хэрэгслийн бохирдлыг арилгах зорилгоор цэвэрлэгээ, ариутгал, идэвхжил сулруулалт хийх зориулалттай техник, багаж хэрэгсэл, хамгаалах хувцсаар хангагдсан, мэргэжлийн бүрэлдэхүүнтэй Зэвсэгт хүчний нэгтгэл, ангид томилгоожсон орон тооны болон орон тооны бус бүлэг, тасаг, салаа хүртэлх хүчийг;

2.1.2. "мэргэжлийн байгууллага" гэж Улсын онцгой комисс, орон нутгийн онцгой комиссын шийдвэрээр байгуулагдсан төрийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн шинжээчийн бүлгийг;

2.1.3. цацраг, хими, биологийн гаралтай гамшиг болон бусад нэр томьёог Гамшгаас хамгаалах тухай хууль болон цэргийн нэр томьёоны тайлбар тольд зааснаар ойлгоно.

Гурав. Бүлгүүдийн ажиллах зарчим

3.1. Тусгай цэвэрлэгээ хийхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1. нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх;

3.1.2. томилгоот бүлэг орон тооны техник, багаж, хамгаалах хэрэгслийн хүчин чадал, боломжийн хүрээнд үүрэг гүйцэтгэх;

3.1.3. тусгай зориулалтын техник, хамгаалах хэрэгслийг зааврын дагуу ашиглах;

3.1.4. мэргэжлийн алба хаагчдаар томилгоожсон байх.

Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт

4.1. Цацраг, хими, биологийн гаралтай гамшгийн үед Улсын онцгой комисс болон аймаг, нийслэлийн онцгой комиссоос Зэвсэгт хүчнээс дэмжлэг авах хүсэлт гаргасан тохиолдолд Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар Тусгай цэвэрлэгээний бүлэг (цаашид "цэвэрлэгээний бүлэг" гэх)-үүд үүрэг гүйцэтгэнэ.

4.2. Зэвсэгт хүчний Жанжин штаб нь Монгол Улсын нутаг дэвсгэрт химийн хортой болон аюултай бодис, цөмийн болон цацраг идэвхт үүсгүүр алдагдсан, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарч, гамшгийн нөхцөл байдал үүссэн үед тагнуулын болон цэвэрлэгээний бүлгүүдийн захиргааны болон мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

4.3. Улсын онцгой комисс (УОК), аймгийн онцгой комисс (АОК), нийслэлийн онцгой комисс (НОК) нь гамшгийн үед шийдвэр гаргах, хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, Зэвсэгт хүчний Жанжин штабын шуурхай удирдлагын бүлэгтэй харилцан ажиллагаатайгаар удирдлагыг хэрэгжүүлнэ.

4.4. Тагнуулын болон цэвэрлэгээний бүлгийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагатай харилцан ажиллагааг Зэвсэгт хүчнээс УОК болон АОК, НОК-т томилогдсон холбогч офицер зохион байгуулна.

4.5. Тагнуулын болон цэвэрлэгээний бүлгийг Зэвсэгт хүчний Жанжин штабын харьяа ангиудад Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга, бусад нэгтгэл, ангиудад тухайн төрлийн цэргийн командлагч, удирдах газрын даргын бэлэн байдлыг хангах удирдамжаар томилгоожуулна.

4.6. Гамшгийн цар хүрээнээс хамаарч тагнуулын болон цэвэрлэгээний бүлгийг шаардагдах хүн, техник хэрэгслээр хүч нэмэгдүүлэх арга хэмжээг Зэвсэгт хүчний Жанжин штабын Шуурхай удирдлагын бүлгийн даргын саналыг харгалзан Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын шийдвэрээр хэрэгжүүлнэ.

4.7. Тагнуулын болон цэвэрлэгээний бүлэг нь орон тооны техник, багаж, хамгаалах хэрэгслийн хүчин чадал, боломжид тулгуурлан үүрэг гүйцэтгэх бөгөөд бүлгийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй арга хэмжээг бүлгийн дарга хариуцна.

4.8. Террорист үйлдлээс үүдэн гамшиг болсон тохиолдолд Зэвсэгт хүчний Жанжин штабын Шуурхай удирдлагын бүлгийн даргын шийдвэрээр бүлгийн бие бүрэлдэхүүн зэвсэг, галт хэрэглэл, агсамж, дуулга бусад хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгэнэ.

4.9. Тусгай цэвэрлэгээний ажлыг гүйцэтгэсэн тухай актыг бүлгийн дарга энэхүү журмын нэгдүгээр загварт заагдсан маягтын дагуу үйлдэж, томилон ажиллуулсан нэгтгэл, ангийн захирагчаар батлуулан, зарцуулсан бодис, уусмал, зардлын тооцоог Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлнэ.

Тав. Байгууллага болон хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг

5.1. Зэвсэгт хүчний Жанжин штаб дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

5.1.1.бүлгийн ажиллах зааврыг баталж, мөрдүүлэх;

5.1.2.тусгай цэвэрлэгээний бүлгийн тусгай зориулалтын техник, багаж, хамгаалах хэрэгслийг шинэчлэх, бодис уусмалын нөөц бүрдүүлэх, бүрэлдэхүүний гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалд хамруулахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгуулан хэрэгжилтийг хангах;

5.1.3.томилгоот бүлгийг томилгоожуулах, бэлэн байдал, сургалт бэлтгэл, бүх төрлийн хангалтыг зохион байгуулах;

5.1.4.тусгай цэвэрлэгээний ажлын явцад бүлгийн алба хаагчид хордсон, гэмтсэн, эрүүл мэнд хохирсон тохиолдолд “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу хөнгөлөлт, нөхөн төлбөр, тэтгэмж олгох.

5.2. Орон нутгийн засаг захиргааны байгууллага дараах үүргийг хүлээнэ.

5.2.1.гамшгийн хор уршгийг арилгахад тусгай цэвэрлэгээний бүлэгт шаардлагатай материал хэрэгсэл, дэд бүтцийг ашиглуулах болон үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх.

5.3. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын эрх, үүрэг:

5.3.1.гамшиг үүссэн тухай зарлан мэдээллийг явуулах;

5.3.2.цацрагийн үүсгүүр болон химийн хорт бодис алдагдсан газар орон, объектын хамгаалалтыг зохион байгуулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах, аюултай бүсийг тойрох тэмдэг, тэмдэглэгээ байрлуулан тагнуулын болон тусгай цэвэрлэгээний бүлгийн ажиллах нөхцөлийг хангах;

5.3.3.шаардлагатай тохиолдолд тагнуулын болон тусгай цэвэрлэгээний бүлэгт хүн, техникээр дэмжлэг үзүүлж, мэдээ, мэдээлэл цуглуулах, нэгтгэх, солилцох;

5.3.4.гэнэтийн тохиолдол үүссэн үед анхан шатны эмнэлгийн тусламж үзүүлэх, эмнэлгийн байгууллагад шуурхай хүргэх.

5.4. Иргэний эрх, үүрэг

5.4.1.бүлгийн бүрэлдэхүүний албан үүргийнхээ дагуу тавьсан шаардлагыг биелүүлж, цацрагийн үүсгүүр, химийн хорт бодис алдагдсан районоос яаралтай гарч аюулгүй байдлаа хангах.

Зургаа. Тусгай цэвэрлэгээний ажлын
зардал, санхүүжилт, нөхөн олговор

6.1. Зэвсэгт хүчний Жанжин штаб нь Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7-д заасан гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон зардлыг УОК болон АОК, НОК-т хүргүүлж шийдвэрлүүлнэ.

6.2. Энэхүү журмын хоёрдугаар загварт заагдсан зардлын тооцооллыг баримтлан тооцоолно.

6.3. Химийн тусгай тоноглолтой техник, багаж, эд хэрэгсэл эвдэрсэн, тусгай зориулалтын хувцас, хамгаалах хэрэгсэл гэмтсэн тохиолдолд түүнийг засварлах, нөхөн хангах, худалдан авах асуудлыг тухайн үеийн ханштай дүйцүүлж мөнгөн хэлбэрээр УОК болон АОК, НОК шийдвэрлэнэ.

6.4. Тагнуулын болон тусгай цэвэрлэгээний бүлгийн алба хаагчид цацраг идэвхт, химийн хортой болон аюултай бодис, халдварт өвчний голомтод ажилласан тохиолдолд хордлого тайлах, сэтгэл зүй, бие бялдрын нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд хамруулах зардлыг УОК болон АОК, НОК шийдвэрлэнэ.

Долоо. Хориглох зүйл

7.1. Тагнуул болон тусгай цэвэрлэгээний бүлэг үйл ажиллагаандаа дараах зүйлийг хориглоно:

7.1.1.Мэргэжлийн байгууллагын дүгнэлт гараагүй, алдагдсан химийн хорт бодисын төрөл, ангилал тогтоогдоогүй газар орон, объектод цэвэрлэгээний бүлгийг ажиллуулах;

7.1.2.Тагнуулын болон тусгай цэвэрлэгээний бүлгийн орон тооны техник, багаж, хамгаалах хэрэгслийн хүчин чадал, боломжоос давсан хордолттой газар орон, объектод бүлгийг ажиллуулах;

7.1.3.Гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамрагдаагүй алба хаагчийг ажиллуулах.

Найм. Хяналт, хариуцлага

8.1. Батлан хамгаалах яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар тусгай цэвэрлэгээний бүлгийн журмын хэрэгжилтэд хяналт тавина.

8.2. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.